

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Дүүргийн хэмжээнд хэрэгжих буй төсөл, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

НЭГ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, нийслэл, дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулсан төсөл, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төсөл, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой үнэлэхэд чиглэгдсэн болно. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 206, 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэл болгов.

ХОЁР. Төсөл хөтөлбөрүүдийн товч танилцуулга:

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тулгуурлан дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх 11 төсөл, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг 2024 оны 12 дугаар сарын 02-05-ны өдрийн хооронд зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тэргүүлэгчдийн 2020 оны “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр батлах тухай А/04, 2021 оны “Боловсрол” төсөл батлах тухай А/22, “Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх” төсөл батлах тухай А/23, “Нийгмийн эрүүл мэнд” төсөл батлах тухай А/35, “Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” төсөл батлах тухай А/36, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл батлах тухай А/37, 2022 оны “Ахмадад ээлтэй дүүрэг” төсөл батлах тухай 9/02, “Хөдөлмөр эрхлэлтийг тэмжих төсөл”-ийг батлах тухай 9/03, тогтоолоор баталсан төсөл, дэд хөтөлбөрүүдийн 24 зорилго, 120 үйл ажиллагааны 2024 онд хэрэгжүүлэх 142 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

“Гэр хорооллын 10,000 айл өрхийн нүхэн жорлонг сайжруулах” төсөл батлах турхай А/26, “Ногоон орчинг нэмэгдүүлэх” хөтөлбөр батлах тухай А/17, “Цахим дүүрэг” төсөл батлах тухай 11/05 дугаар тогтоолоор баталсан төсөл, дэд хөтөлбөрүүдийн 13 зорилго, 34 үйл ажиллагааны 2021-2024 онд хэрэгжүүлэх 33 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд:

№	Төслийн нэр	м	с	×	м	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь
---	-------------	---	---	---	---	-------------	-------------------

				2022	2023	2024	2022	2023	2024
1	“Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” төсөл	3	8	17	14	13	98,2	96,6	95,3
2	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл	5	14	15	19	13	81,66	95	92,3
3	“Нийгмийн эрүүл мэнд” төсөл	5	20	30	20	21	89,7	92	93,6
4	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл	3	6	17	14	14	93,6	90	91,4
5	“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх” төсөл	3	7	10	20	18	99,2	86,6	98,3
6	“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр	6	33	25	15	15	98,4	95	88
7	“Ахмадад ээлтэй дүүрэг” төсөл	3	16	17	23	21	97,1	93,3	94,5
8	“Боловсрол” төсөл	6	16	19	27	23	85,6	90	93,9
9	“Ногоон орчныг нэмэгдүүлэх” төсөл	7	15	23	15	14	87,3	90,7	96
10	“Гэр хорооллын 10000 айлын нүхэн жорлонг сайжруулах” төсөл	2	9	14	10	11	94,5	85	91
11	“Цахим дүүрэг” төсөл	4	10	0	8	8	0	65	90,7
12	“Хариуцлагатай аав, ээж” төсөл					хэрэгжээгүй			
Нийт		47	154	187	185	142	92,5	89	93,1

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт

№	Төсөл хөтөлбөрийн нэр	2021	2022	2023	2024	Нийт
1	“Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” төсөл	141,8 сая	343,6 сая	29,8 сая	63,2 сая	578,4 сая
2	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төсөл	600,3 сая	44,6 сая	28,7 сая	21,5 сая	695,1 сая
3	“Нийгмийн эрүүл мэнд” төсөл	9 сая	7,6 сая	28,4 сая	38,5 сая	75,4 сая

4	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төсөл	-	108,3 сая	185,1 сая	194,3 сая	559,7 сая
5	"Иргэдийн боловсролыг соёлын дээшлүүлэх" төсөл	9,0 сая	23,4 сая	25,9 сая	274,9 сая	333,3 сая
6	"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөр		4,3 сая	7,9 сая	10,2 сая	22,4 сая
7	"Ахмадад ээлтэй дүүрэг" төсөл	-	107,2 сая	126,5 сая	217,5 сая	451,2 сая
8	"Боловсрол" төсөл	79,0 сая	77,3 сая	146,0 сая	107,4 сая	409,7 сая
9	"Ногоон орчныг нэмэгдүүлэх" төсөл	1,7 тэрбум	91,7 сая	1,3 тэрбум	339,5 сая	3,4 тэрбум
10	"Гэр хорооллын 10000 айлын нүхэн жорлонг сайжруулах" төсөл	-	6,0 тэрбум	10,6 тэрбум	10,9 тэрбум	26,5 тэрбум
11	"Цахим дүүрэг" төсөл	-	-	102,0 сая	113,0 сая	215,0 сая

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА *тууга* С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Мөнхзул* Б.МӨНХЗУЛ

“ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ” төсөл

Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн, хандлагыг өөрчилж, хувь хүн болон гэр бүл, хамт олны идэвх оролцоонд тулгуурласан нэгдмэл үйл ажиллагаагаар эрсдэлт хүчин зүйлийг тооцон, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулж, эрүүл гэр бүлийг бий болгох зорилгоор хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 3 зорилтын хүрээнд 8 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Эмнэлгийн эмч, мэргэжилтний ур чадвар нэмэгдсэнээр эх, нярайн эндэгдэл, өвчлөл буурсан, эмчилгээний нэр төрөл нэмэгдсэн, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.
- ✓ Иргэдийн эрүүл мэндийн боловсрол сайжирч, байгууллагын удирдлага, хамт олны хандлага, оролцоо нэмэгдсэн байна.
- ✓ Өвчлөлийг эрт илрүүлсэнээр өвчлөл багассан байна.

“Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” төслийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	ЕБС, байгууллага, ААН-ийн эцэг, эхийн зөвлөлтэй хамтран “Эрүүл гэр бүл” сэдэвт асран хамгаалагчдын оролцоог хангасан сургалтуудыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ- 100% ХШҮ-70% болгож бууруулсан	Сургалтад хамрагдсан эцэг, эхийн зөвлөлийн тоо зорилтод түвшинд хүрээгүй тул 100% хэрэгжсэн байх боломжгүй.
Хяналт шинжилгээний үнэлгээ 95,3%			

Дүгнэлт:

1.Эмнэлгийн эмч, мэргэжилтний ур чадвар нэмэгдсэнээр эх, нярайн эндэгдэл, өвчлөл буурсан, эмчилгээний нэр төрөл нэмэгдсэн, тоног төхөөрөмжөөр хангах тал дээр тодорхой үр дүн гарсан ч эх нярайн эндэгдлийн өвчлөл буурсан эсэх үзүүлэлт тайланд дурдагдаагүй тул мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран судалгааг нарийвчлан гаргах шаардлагатай.

2.Эх, хүүхэд нөхөн үржихүйн чиглэлээр гадаад улс орны болон дотоодын эмнэлгүүдийн туршлага судалсан 220 албан хаагчдаас сайн туршлагаа хэрэгжүүлсэн байдал үр дүн тодорхойгүй.

3.Иргэдийн эрүүл мэндийн боловсрол сайжирснаар ямар эерэг үр нөлөө гарсан талаар тайланд тусгах шаардлагатай.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЗУЛ

“ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ СЭРГИЙЛЭХ” төсөл

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх үйл ажиллагаанд төр болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах чадавхийг сайжруулж, салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгоор энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 5 зорилтын хүрээнд 14 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Халдварт өвчний тандалтыг эрчимжүүлснээр илрүүлэлт нэмэгдэж, дархлаажуулалтын талаарх иргэдийн мэдлэг, хандлага сайжирч, хамралт нэмэгдсэн байна.
- ✓ Хепатитын вируст халдварын эрт илрүүлгийн хувь нэмэгдэж, элэгний төрөл бүрийн өвчлөл, хавдар буурна.
- ✓ Иргэдийн сүрьеэ өвчний талаарх мэдлэг сайжирч, сорьц тээвэрлэлт, ДОТС-ын эмийн хяналт сайжирна.
- ✓ БЗДХ-ын талаарх иргэдийн мэдлэг сайжирч, хандлага өөрчлөгдсөнөөр өвчлөл буурч, эрт илрүүлэг, эмчилгээний хувь нэмэгдсэн байна.
- ✓ Шинэ коронавирус халдварыг бууруулж хариу арга хэмжээний бэлэн байдал хангаж ажилласан байна.

“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төслийн 2024 оны жилийн эцэсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, цусны донор, анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, их дээд сургууль, коллежийн оюутнуудыг В вирүст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах, сайн дурын дархлаажуулалтыг өргөжүүлэх	Гүйцэтгэлийн үнэлгээ-77% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 45, хүрсэн 35 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Жирэмсэн эмэгтэй тэмбүү өвчнөөр оношлогдсон тохиолдолд хавьтлын хамт хяналтанд авч бүрэн эмчлэн эрүүлжүүлэх	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-30% болгож бууруулсан	Тайланд тусгасан тооноос зөрүүтэй байна. Эрүүл мэндийн төвөөс 5431 жирэмсэн эхээс тэмбүү өвчнөөр оношлогдсон 128 эх байна.
Хяналт шинжилгээний үнэлгээ 92,3%			

Дүгнэлт:

1.Хүн ам, эрсдэлт бүлгийн дунд хепатитийн В, С вирүст халдварын илрүүлгийг үе шаттайгаар зохион байгуулах, эрсдэлт зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалтын хүрсэн түвшинд 105 удаа сургалт зохион байгуулсан байна. Хаана ямар байгууллагад зохион байгуулсан, гарсан үр дүнгийн талаар тайлагнах;

2.Үйл ажиллагааны дагуу цусны донор, анагаах ухааны чиглэлээр бэлтгэсэн мэргэжилтний тоо, их дээд сургууль, коллежийн оюутнуудыг хамруулсан эсэх талаар тайлагнах;

3.Жирэмсэн эмэгтэй тэмбүү өвчнөөр оношлогдсон тохиолдолдын тоог бодитой тайлагнах, хавьтлын хамт хяналтанд авч бүрэн эмчлэн эрүүлжүүлэх талаар хийж хэрэгжүүлсэн ажил тодорхойгүй, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан өвчлөлийн хэмжээг тодохойлох;

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНХЗУЛ

“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД” төсөл

Халдварт бус өвчинөөс урьчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эрт илрүүлгийг эрчимжүүлж, төр хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн идэвхи оролцоо, мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх замаар өвчлөлийг эрт үед илрүүлж, нас баралтыг бууруулах зорилгоор энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 5 зорилтын хүрээнд 20 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Дүүргийн хүн амын 70%-д эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл, эрүүл мэндийн боловсролыг олгосон, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын хувь жил бүр 5%-иар нэмэгдэж, чихрийн шижин, зүрх судас, хавдрын өвчлөл эрт оношлогдож, эрүүлжилт нэмэгдсэн байна.
- ✓ Хорт хавдрын эрт илрүүлэг нэмэгдэж, нас баралт буурсан байна.
- ✓ Иргэдийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг 15 хувиар нэмэгдсэн байна.
- ✓ Хүний дотоод болон гадаад будлиан, бухимдал, стресс, тайван биш байдал, сэтгэл зовох зэрэг сэтгэл зүйн өөрчлөлтүүдээс болж үүсэх сэтгэцийн тулгамдсан асуудал буурсан байна.
- ✓ Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж, өвчлөл буурч, эрүүлжилт нэмэгдсэнээр эрэгтэйчүүдийн дундаж наслалт нэмэгдсэн байна.

“Нийгмийн эрүүл мэнд” төслийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Хүүхдийн хавдрын өвчлөлийн судалгааг хийж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь тодорхойгүй.
2	Дүүргийн нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн хавдрын эрт илрүүлгийн үзлэгийг тогтмол зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-86% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 40, хүрсэн 37,6 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 91,4%			

Дүгнэлт:

1.Хүн амд мэдээ мэдээлэл, эрүүл мэндийн боловсролыг олгосноор урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын хувь нэмэгдэх эсэх, голлох өвчин болох чихрийн шижин, зүрх судас, хавдрын өвчлөл буурсан эсэх судалгааг өмнөх оны мөн үеийн судалгаатай харьцуулах шаардлагатай байна.

2.Хавдрын өвчлөлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгаанд хамрагдсан 39,259 иргэнээс хүүхэд судалгаанд хамрагдсан эсэх, хүүхэд хамрагдсан бол хавдар илэрсэн эсэх нь тодорхой биш байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь тодорхойгүй.

3.Иргэдийг эрт илрүүлэг үзлэгт хамруулах, эрүүл мэндийн даатгалд хамруулах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, сурталчилгааг өргөжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНХЗҮЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ” төсөл:

Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэдийн хэрэгцээг тодорхойлон мэргэжлийн ур чадвар олгож тогтвортой ажлын байранд зуучлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэн иргэдийн амьдарлын түвшинг дээшлүүлэхэд зорилгоор энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 3 зорилтын хүрээнд 6 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хэрэгцээний болон суурь судалгаанууд гарч, судалгаанд хамрагдсан иргэдийн 20 хувийг сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулсан байна.
- ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, бүтээгдэхүүний чанар, дизайн, өнгө үзэмж сайжирсан байна.
- ✓ Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжиж, зорилтот бүлэгт чиглэсэн ажлын байр нэмэгдсэн байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн суурь судалгааг гарган, хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг тодорхойлох	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 3, хүрсэн 2 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Ажил олоход хүндрэлтэй иргэдэд чиглэсэн зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 6, хүрсэн 5 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн
3	Бичил бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад нь дэмжлэг үзүүлэх болон ажилд зуучлах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран уулзалт, зөвлөгөө зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 8, хүрсэн 7 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 91,4%			

Дүгнэлт:

1. Ажил олоход хүндрэлтэй иргэдийн суурь судалгааг гаргасан боловч хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг тодорхойлох ажил зохион байгуулах;

2.Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтыг байнгын ашиглалтад хүлээж авах ажлын хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл байгаа боловч оролцоо хангалтгүй.

3.Дүүргийн хэмжээнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо тайланд дурдагдаагүй, үүний хэдэн хувьд бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийсэн үр дүнг тайлагнах;

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА *туулмаа* С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Мөнхзул* Б.МӨНХЗУЛ

“ИРГЭДИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ” төсөл

Тогтвортой хөгжлийн суурь дархлаа иргэдийн соёлын боловсролыг дэмжих, мэргэжлийн боловсон хүчээр хангагдсан стандартад нийцсэн соёл, урлагын үйлчилгээний барилгыг шинээр бий болгож, шинэлэг бүтээгдэхүүн, бүтээлч үйлчилгээг нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус олон улсын байгууллага, иргэдийн оролцоотойгоор уламжлагдан ирсэн өв, соёл, үнэт зүйлээ хамгаалах, өвлүүлэх, сурталчилан таниулах, баяжуулах ажлыг шат дараатай зохион байгуулж, соёлын дэвшилтэт хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадвартай оюунлаг, хүмүүнлэг, соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 3 зорилтын хүрээнд 7 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Тогтвортой хөгжлийн суурь дархлаа болох иргэдийн соёлын боловсролыг дэмжсэн шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулагдаж, үр дүнгээ тооцсон байна.
- ✓ Соёл урлагийн үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмж нэмэгдэж, шинэлэг бүтээгдэхүүн, бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтүүлэн, сурталчилсан байна.
- ✓ Өв соёл, уламжлал, үнэт зүйлээ хамгаалж, өвлүүлэх сурталчлах ажлаар дамжуулан өв соёл, уламжлалаа дээдэлдэг иргэдийн төлөвшүүлсэн байна.

“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх” төслийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран түүх соёлын үл хөдлөх дурсгал болох булш, хиргисүүрийн тооллогыг хийж, хамгаалах ажлыг зохион байгуулна.	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	14 хөшөөний хэдэд нь засвар хийх 7 сая төгрөгний санхүүжилт шийдэгдсэн ч засвар үйлчилгээ хийгдээгүй.
Хяналт шинжилгээний үнэлгээ 98,3%			

Дүгнэлт:


1.Иргэд болон сурагчдын түүх соёлын мэдлэгийг дээшлүүлэх, эх орноороо бахархан дуурайх үзлийг бий болгох, иргэн бүрийг түүх соёлын мэдлэг мэдээлэлтэй болгох, соёлч иргэнийг бий болгох үр дүн бүхий ажлыг зохион байгуулах;

2.Түүхийн дурсгалт 14 хөшөөний засвар шинэчлэлт хийх, угийн бичиг хөтөлдөг хүүхдийн тоог нэмэгдүүлэх ажил зохион байгуулах;

3.Гэр бүлийн соёл хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, угийн бичиг хөтөлдөг хүүхдүүдийн тоо нэмэгдсэн эсэх тодорхой тайлагнах;

4.Өв тээгч нарыг алдаршуулах ажлыг зохион байгуулсан, иргэдийг төлөвшүүлсэн байдал тодорхойгүй байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЗУЛ

“ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ” дэд хөтөлбөр

Дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд жендерийн мэдрэмжтэй арга зүй нэвтрүүлэх, жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц ажиллагаа явуулах, гэр бүл, нийгэм соёлын болон бүх нийтийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор хэрэгжиж байна.

Дэд хөтөлбөр нь 2020-2025 онд 2 үе шаттай, 1 дүгээр үе шатыг 2020-2022 онд хэрэгжүүлэх ба “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийн 2017-2021 оны үйл ажиллагаатай, 2 дугаар үе шатыг 2023-2025 онд хэрэгжүүлж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтын жендерийн тэгш байдлыг хангах болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанарыг сайжруулах зорилт, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилттэй тус тус уялдуулахаар тусгажээ.

Дэд хөтөлбөр нь 6 зорилтын хүрээнд 33 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

✓ Дүүргийн төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ, жендерийн мэдрэмжтэй болсон байна.

✓ Жендерийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага өөрчлөгдсөн, жендерийн мэдлэг нэмэгдсэн байна.

✓ Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж, нийгэм, соёл, гэр бүлийн доторх идэвх оролцоо нэмэгдэж, өвчлөл буурсан байна.

✓ Хөдөлмөрийн харилцаан дахь хүйсийн ялгаварлалын талаарх гомдол маргаан, ажлын байрны бэлгийн дарамт болон гэр бүлийн, бусад хүчирхийллийн тоо, хувь буурсан байна.

“Жендерийн эрх тэгш байдлыг хангах” хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Жендерийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн шторк, цахим болон хэвлэмэл мэдээлэл, видео хичээлүүдийг сурталчлах.	Гүйцэтгэлийн үнэлгээ-50% ХШҮ-30% болгож бууруулсан	Хүрэх түвшин 10,000, хүрсэн түвшин 3388 байхад 50% байх боломжгүй.
2	Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг сурталчлах, үр дүнтэй ажилласан ААНБ, ТББ, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Гүйцэтгэл 50 хувьтай, 3Г-ын 206 дугаар тогтоолын хүрээнд үнэлгээг бууруулсан.
Хяналт шинжилгээний үнэлгээ 88%			

Дүгнэлт:

1.Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн шторк, цахим болон хэвлэмэл мэдээлэл, видео хичээлүүдийг сурталчлах ажил төслийн хугацаанд 30% байгаа нь хангалтгүй байна.

2.Сургуулиудын хэмжээнд үе тэнгийн дээрэлхэлтийн тандалт судалгаа явуулсан ч дээрх арга хэмжээг зохион байгуулснаар гарсан үр дүн тодорхойгүй байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

туул

С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Б.Мөнхзул

Б.МӨНХЗУЛ

“АХМАДАД ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ” төсөл:

Ахмад настны аж байдлыг дээшлүүлэх, тэдний эрүүл насжилтыг дэмжих, нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, ахмад настны талаар нийгэмд эерэг ойлголтыг төлөвшүүлэхэд нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа хүчин чармайлтыг чиглүүлэхэд энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 3 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Ахмад настны аж байдалд эерэг өөрчлөлт гарна.
- ✓ Ахмад настны эрүүл, урт насжилт нэмэгдэнэ.
- ✓ Ахмад настны чадамжийн үзүүлэлт сайжирна.
- ✓ Ахмад настны амьдрах орчин сайжирна.

“Ахмадад ээлтэй дүүрэг” төслийн 2024 оны эхний хагас жилийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Гэр, орон сууцгүй хүнд нөхцөлд байгаа ахмад настны судалгааг хороо бүрээр нарийвчлан гаргаж холбогдох газруудтай хамтран үе шаттай шийдвэрлэнэ.	Гүйцэтгэлийн үнэлгээ-80% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 5, хүрсэн түвшин 4. ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Ахмадыг зөв хооллолт, дасгал хөдөлгөөний ач холбогдол, эмийн зохистой хэрэглээ, архи, тамхины хор уршгийн талаар сургалт сурталчилгааны ажилд хамруулан, урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллээр хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 5000, хүрсэн түвшин 4666 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
3	Ургийн баяр, угийн бичгийн ач холбогдлыг сурталчилна.	Гүйцэтгэлийн үнэлгээ-80% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 100, хүрсэн түвшин 80 ЗГ-ын 206-р тогтоолоор бууруулсан.
Хяналт шинжилгээний үнэлгээ 94,5%			

Дүгнэлт:

1. Ахмад настны онцлогд тохирсон ажлаар хангах, нийгмийн харилцаанд оролцуулах, ахмад настны ажил амьдралын сайн туршлагаас залуу хойч үед зааж сургах, ахмадын амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулсан боловч ахмад настны чадамжийн үзүүлэлт сайжирсан эсэх тодорхойгүй.

2. Ургийн баяр, угийн бичгийн хөтөлсөн ахмадын тоо тодорхойгүй, ач холбогдолыг сурталчилсан байдал тодорхойгүй.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНХЗУЛ

“БОЛОВСРОЛ” төсөл:

Сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол болон насан туршийн боловсролын үйлчилгээг сурагчдад тэгш хүртээмжтэй, чанар үр дүнтэй хүргэх, багшид мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломж, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 6 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Суралцагчдад боловсролын үйлчилгээ хүртээмжтэй, үр дүнтэй хүрнэ.
- ✓ Суралцах орчин нөхцөл сайжирснаар сургалтын чанар, үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ дээшилнэ.
- ✓ Суралцагчид эрүүл, аюулгүй шим тэжээллэг хоол, хүнсээр тэгш хүртээмжтэй хангагдана. Ерөнхий боловсролын сургуулиад хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамрагдана.
- ✓ Суралцагчид эх оронч сэтгэлгээ, хэл соёл, түүх, ёс заншлаа дээдлэх мэдлэг, ухамсар, ёс зүй, хүмүүжлийн мэдлэгтэй иргэн болж төлөвших суурь тавигдсан байна.
- ✓ Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөл бүрдэнэ.
- ✓ Багш бүрийн мэргэжлийн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөл бүрдэнэ.
- ✓ Багш бүрийн мэргэжлийн болон арга зүйн хөгжилд бодит ахиц гарч, багш мэргэжлийн стандартад нийцэж, багшийн чадамж сайжирсан байна.
- ✓ Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдын элсэлтийн ерөнхий шалгалтад үзүүлсэн амжилт өмнөх жилүүдийнхээс тодорхой үзүүлэлтээр өссөн байна.
- ✓ Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед суралцагчдын тасралтгүй суралцах нөхцөл хангагдсан байна.
- ✓ Иргэдэд насан туршийн боловсролын үйлчилгээ үзүүлэх сургалтын бие даасан байртай болж, өргөжсөн байна.
- ✓ Суралцагч, багш, эцэг эх, олон нийтэд арга хэмжээний үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүртээмжтэй, ил тод хүргэснээр иргэдийн ойлголт мэдлэг, хандлагыг зөв чиглүүлсэн байна.

“Боловсрол” төслийн 2024 оны жилийн эцсийн үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
-----	----------------------	---------	-------------------------------

1	Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартад хяналт тавих, хоол үйлдвэрлэл үйлчилгээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартад хяналт тавьсан үр дүн тодорхойгүй.
2	Ерөнхий боловсролын сургуулийн сурлагын чанар, стандарт хэрэгжилтийг хангах	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Сургалтын чанар өмнөх оныхоос 1,4 хувиар буурсан
3	Суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх багш, нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "IELTS-600" арга хэмжээг хэрэгжүүлэх	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 100, хүрсэн 50 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 93,9%			

1.Сургуулийн цайны газар, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжтэй болгох асуудлыг судлах;

2.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурлагын чанар, стандарт хэрэгжилтийг мэргэжлийн байгууллагатай хамтран шалгалт хийж, шаардлага хангахгүй байгаа байгууллагад холбогдох арга хэмжээг авах;

3.Өдөр өнжүүлэх үйлчилгээний стандартыг хангуулах үйл ажиллагаанд хяналт тавьсан ч үр дүн байхгүй, зөрчил илэрсэн 13, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5,6 дах заалтыг зөрчсөн үйл ажиллагаа явуулах боломжгүй, орчин нөхцөл хангалтгүй, хаах саналтай 11 нийт 24 өдөр өнжүүлэхэд авсан арга хэмжээ тодорхойгүй.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЗУЛ

“НОГООН ОРЧНЫГ НЭМЭГДҮҮЛЭХ” төсөл:

Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ногоон байгууламж бүхий гудамж талбайг бий болгох, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага айл өрх бүрт уриалга хүргүүлэх, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, дүүргийн өнгө үзэмж, иргэдийн ая тухтай, эрүүл аюулгүй амьдрах орчныг сайжруулах, агаар орчны бохирдол, тоосжилтыг бууруулах зорилгоор хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 7 зорилтын хүрээнд 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчны ая тухтай нөхцөл бүрдэж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог хангана.
- ✓ Агаар, хөрс, орчны бохирдол, дуу чимээ, тоосжилт буурна.
- ✓ Хүн ам, малын усан хангамжийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, усны нөөцийг зүй зохистой ашиглах, бохирдох, хомсдохоос сэргийлнэ.

“Ногоон орчныг нэмэгдүүлэх” төслийн 2021-2024 оны үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Нийтийн эзэмшлийн талбайг зүлэгжүүлэх, бут сөөг тарих ажлыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 15000, хүрсэн 13156 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Тэрбум” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх, бий болгох, мод тарьж, арчлан ургуулах, ач холбогдолын талаарх сурталчилгааны ажил зохион байгуулах.	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 4, хүрсэн 2 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 96%			

Дүгнэлт:

1.Нийтийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийт 212000 мод тарихаар зорьсон. Гүйцэтгэлийн хувь 87,7 хувь байгаа нь зорилтот түвшинд хүрээгүй байна.

2.“Ногоон орчныг нэмэгдүүлэх” төсөл нь 2022 онд 76,3 хувийн хэрэгжилттэй 2023 онд 90,7 хэрэгжилттэй, 2024 онд 96% хувийн хэрэгжилттэй байна. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 2022 онд 66306 мод бут сөөгийг тарьж ургуулсан 2023 онд 189797 мод бут сөөг ургуулсан 2024 онд 121016 мод бут сөөгийг тарьж ургуулсан нь дүүргийн нутаг дэвсгэрийн хэдэн хувийг эзэлж байгааг тодорхойлоогүй, үр дүн тооцоогүй байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЗУЛ

“ГЭР ХОРООЛЛЫН 10,000 АЙЛ ӨРХИЙН НҮХЭН ЖОРЛОНГ САЙЖРУУЛАХ” төсөл

Гэр хорооллын 10,000 айл өрхөд стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг барих замаар хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор хэрэгжиж байна.

Төсөл нь 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

✓ Иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөл бүрдэж, стандартад нийцсэн нүхэн жорлонг нэмэгдүүлэх;

✓ Хөрсний бохирдлын талаарх иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, хөрсний бохирдол болон эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

✓ MNS 5924:2015 стандартын дагуу гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, хөрсний бохирдлыг бууруулна.

“Гэр хорооллын 10,000 айл өрхийн нүхэн жорлонг сайжруулах” төслийн 2021-2024 оны үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Батлагдсан журмын дагуу шалгаруулах журам, төсөлд хамрагдах айл өрхийн материал хүлээн авах, хугацаа нөхцлийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар танилцуулж, төсөлд хамрагдах зорилтот айл өрхтэй гэрээ байгуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 10000, хүрсэн 9426 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Гэрээ байгуулсан зорилтот 10,000 өрхийн уламжлалт нүхэн жорлонг стандартад нийцсэн соруулдаг нүхэн жорлонгоор сольж суурилуулах	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 10000, хүрсэн 9203 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн
3	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь төсөлд хамрагдан жорлонгоо өөрчлүүлсэн айл өрхийн жорлонгийн бохир ус сорох, халдваргүйтгэх үйлчилгээг жилд 2-4 удаагийн давтамжтайгаар хийж гүйцэтгэнэ	Гүйцэтгэлийн үнэлгээ-100% ХШҮ-70% болгож бууруулсан	Хүрэх түвшин 10000, хүрсэн 9185 ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 91%			

Дүгнэлт:

1.Төсөл хэрэгжиж эхлэх үед 84234 өрхийн 73,4 хувь нь гэр хороололд амьдарч, 47173 нүхэн жорлонтой гэсэн тоон судалгаа байна. Үүнээс эхний ээлжид хөрс рүү шууд бохироо шингээдэг 28571 өрхийн 35 хувь буюу 10,000 айл өрхийн нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар солихоор төлөвлөсөн. 2021-2024 онд тайлант хугацаанд нийт 9203 өрхөд хийж гүйцэтгэсэн, 794 дутуу байна.


2.2021-2024 онд хийж гүйцэтгэсэн 9203 өрхийн ариун цэврийн байгууламжийн ашиглагдаж байгаа тоо, эвдэрч гэмтсэн жорлонгийн тоо, сэргээн засах ажил хийгдсэн эсэх талаар тайлагнах

3.Гэрээ байгуулсан 9426 айл өрх байна. Үүнээс 20 өрх буюу нийт ариун цэврийн байгууламжаа шинэчилсэн өрхийн 0,2 хувьд хөрснөөс түүвэрчилсэн байдлаар дээж авч хөрсний чанарын шинжилгээ хийсэн нь хангалтгүй, хөрсний бохирдол буурсан эсэх нь тодорхойгүй байна.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХЗУЛ

“ЦАХИМ ДҮҮРЭГ” төсөл

Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, салбар бүрт цахим үйлчилгээг хөгжүүлж чанартай хүртээмжийг нь сайжруулах, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх бүрдүүлэх зорилгоор энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төсөл нь 2023-2024 онд хэрэгжих бөгөөд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна гэж тодорхойлсон. Үүнд:

- ✓ Төрийн үйлчилгээ анхан шатны нэгжид цахимаар хурдан шуурхай хүрнэ.
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.
- ✓ Санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай, хялбар гаргах, шийдвэрлэх боломж нэмэгдэнэ.
- ✓ Цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

“Цахим дүүрэг” төслийн 2023-2024 үр дүн:

Д/д	Арга хэмжээний заалт	Үнэлгээ	Бууруулсан үнэлгээний тайлбар
1	Автобусны буудал дээрх зарлан мэдээлэх электрон самбар байршуулах /автобусны буудлын байршил, ирэх хугацааг, бүх чиглэлийн байршлыг харуулах/	Гүйцэтгэлийн үнэлгээ-50% ХШҮ-0% болгож бууруулсан	Хэрэгжээгүй ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
2	Албан хаагчдыг нэгдсэн системд холбох	Гүйцэтгэлийн үнэлгээ-90% ХШҮ-70% болгож бууруулсан	Бүрэн хэрэгжээгүй ЗГ-ын 206-р тогтоолоор үнэлсэн.
Хяналт шинжилгээний үнэлгээ 90,7%			

Дүгнэлт:

1.Автобусны буудлуудад иргэдийг ая тухтай үйлчилгээг ханган зорилгоор чиглэл, цаг минут харах цахим самбар байршуулах ажил хөрөнгө оруулалт санхүүжилтгүйн улмаас зогссон шалгаан нөхцлийг тодруулан тайлагнах;

2.Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглахаар файл серверийг бэлтгэн суурилуулан ажиллуулсан ч одоогийн ашиглаж байгаа төхөөрөмж хэрэгцээ шаардлагад нийцэхгүй олон төрлийн эвдрэл гэмтэл гарч ашиглагдаагүй байгаа. Шинээр сайн чанарын төхөөрөмжөөр солих шаардлагатай.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНХЗУЛ